

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Буд	Дугаар	L294
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Цагаан-Уул сум
Төрсөн газар	Цагаан – Уул сум	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Жалханз хутагтын хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨАБ 009
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 7	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат

### Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Жалханз хутагтын хүрээ

Мөнхбат:Тэгэхээр Буд гуай бол Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч вангийн хошууны хүрээ хийд сүмийн одоо буддын томоохон төв хүрээ хийд болох Жалханз хутагтын хүрээнд долоон наснаасаа эхлэн шавилан сууж үндсэндээ тус хүрээг одоо үрэгдэж устгал нь тэнд шавилж байсан ийм одоо Жалханзын хүрээний унаган шавь нараас үлдсэн одоо маш цөөхөн тооны хүний нэг ээ гэж ингэж сүм нутгийнхан ярих юм.Ингээд бид нар Буд гуайнд зочлон ирж энэхүү ярилцлагыг авч байна.Тэгэхээр түүхэнд энэ нэг ийм юм бичигдсэн байгаа юм.Жалханзын хүрээний гарал үүслийн талаар, жишээлбэл 1872 онд энэ хөрш Цэцэрлэг сумын нутаг дахь Тэсийн хүрээнд ганжуур эргэж явсан хүмүүс буудаллаж байсан тэр Хөшөөт орчим билүү, лав л Хөшөөт гээд, би хоёр дахь үгийг нь санахгүй байна.Энэ газар буудаллаад, тэр газар шинжиж энд одоо хүрээ хийд байгуульа гээд ингээд 1873 онд анхны цогчин дуганыг барьж 1876 онд аравнайлсан юм гэнэ лээ гэсэн одоо ийм нэг түүхэн баримт байх юм, зарим нэг түүх сударт бичсэнээр бол.Тэгэхээр түрүүн энэ хийдийн хамба багш Эрдэнэбат багштай ярьж байхад багш бол энэ Жалханз хутагт, хүрээ хоёр чацуу юм гэнэ лээ гээд Жалханз хутагтын одоо намтрыг гаргаж ирээд үзсэн.1874 онд төрсөн байдаг, тэгэхээр тэр хүрээний анхны дуганыг бол 1873 онд барьсан юм гэнэ лээ гэж ингэж түүхэнд тэмдэглэгдсэн юм байна лээ.Тэгэхээр энэ бол түүхийн хувьд бол нэг л жилийн , одоогийн тооллоор бол нэг л зөрүүтэй ийм баримтууд юм. Тэгэхээр бараг одоо тэр барагцаанд байсан л юм болов уу гэсэн таамаглал төрж байгаа юм. Энэ тал дээр таны бодол?

Буд: Тэр амьтны ярианаас бол одоо яг би ийм л юм дуулж авсан байна л даа.Тэр Жалханзын хүрээ чинь анх олон газар нутаглаж явж байгаад, Өвгөн хүрээ гэдэг дээр одоо байгуулагдаад, Өвгөн хүрээндээ бас тэр нь одоо хуухууд идэгдсэн /хятадын хар цэрэг болов уу/ гэж ярьдаг юм байна лээ, амьтан. Тэгээд тэндээс л сүүлд нь одооны, тэгээд л сүүлд нь тэр хуучин одоо сүүлийн үед байж байсан энэ хонхордоо, одоо Жалханзын хүрээний хонхор л гэж нэрлээд байгаа.Одоо бол гурван модны хонхор гэж байгаа юм.Гурван модны хонхор бол баруун,

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жалханзын гэгээний өөрийн тэр ард талд байшингийнхаа, тэр дуганыхаа ард талд тарьсан гурван мод, одоо энэ гурван мод үлдчихсэн байгаа. Одоо энэ гурван модны хонхор гэж л нэр өгчихсөн байгаа.Энэ газар л анх байгуулсан юм гэнэ лээ.

Мөнхбат: Он тооллын хувьд бол саяын энэ тоонууд хэр бодитой тоонууд бол?

Буд: За тэр нэлээн дөхүү тоо л байлгүй дээ.Иймэрхүү л тоо хэлдэг юм байна лээ. Тэгээд Жалханз гэгээний чинь бол тавин нас хүрээд л таалал төгссөн гэж энэ Алтангэрэл, Раш гуай энэ тэр олон хүн очиж Улаанбаатарт нас барчихсаныг нь үхэрт явна аа, үхэр тэргээр явж шарилыг нь авчирна.Тэгээд Жалханз гэгээнийг таалал төгссөн байхад нь авчрахдаа их давсалчихсан тэгж авчирсан юм гэнэ лээ.

Мөнхбат: Тэгэхээр тавин насандаа одоо өнгөрсөн, таалал төгссөн гэж байна. Тэгэхээр энэ бол түүхэнд бол 1923 он мөн биз?

Буд: Тийм, тийм. Мянга есөн зуун хорин гурван, мянга есөн зуун хорин хоёр...Тийм, мянга есөн зуун хорин гурван онд.

Мөнхбат: Тэгэхээр хорин гурван онд тавин насандаа таалал төгссөн гэхээр, үндсэндээ төрсөн нь бол 1873 он гэж таарч байна. Тэгэхээр яг энд суурьшиж байсан. Жалханзын хүрээтэйгээ одоо Жалханз хутагт маань нас чацуу гэвэл одоо тэр 1873 оны үе бол, далан гурван он гэдэг бол багцаа тоо байх нь ээ, тийм ээ?

Буд: Тийм, багцаа нь. Гэхдээ Жалханз гэгээн чинь гурван настайд нь тодруулж авчирсан юм аа гэж гурван настайд нь тодруулсан гэж тийм яриатай байдаг байсан. Тэр гурван настайд нь тодруулахаас урьд нь энэ хүрээ байсан юм уу, тэр хавьд л байгуулсан юм уу гэдгийг нь одоо мэдэхгүй юм.Тэгээд осолдохгүй л тавин нас хүрээд 1923 онд тэр Раш гуай, Алтангэрэл гуай энэ тэр авчирч энд яасан юм гэж, тэр гүдэнд авчирч залсан юм гэж. Гүдэн дуган гэж байж байхдаа...

Мөнхбат: Тэгэхээр манай судалгааны баг одоо нэлээн хэд хоногийн өмнө Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутагт ажилласан.Ингээд Хөвсгөл аймгийн Арбулаг суманд ажиллаж байхад, тэнд одоогийн Арбулаг сумын хоёрдугаар багийн төвөөс нэг баруун хойш нэг км орчимд зайд нэгэн үл мэдэгдэх хүрээний туурин дээр бас судалгаа хийсэн. За энэ хүрээий түүр бол одоо бид нарын энэ мөрдлөгө болгоод явж байгаа Бямбын Ренчин академчийн жагсаалтанд бол ороогүй, байхгүй байгаа. Аа нутгийнхан бол тэрнийг бол одоо сайн мэддэг. Одоо арав гаруй дугантай, доохон талдаа одоо төдийлэн сайн судлагдаагүй, дөрвөлжин булш.Нэлээд хэдэн дөрвөлжин булштай.Арваад дөрвөлжин булштай, тийм нэг уулын энгэр дэвсэг сайхан газар байгуулагдсан хүрээ байгаа.Тэр хүрээг бол нутгийнхан бол газар усных нь нэрээр Үзүүр хадны хүрээ гэж ингэж нэрлэх юм.

Буд: За тийм, тэр Үзүүр хадны хүрээ дуулж байсан юм байна.

Мөнхбат:Тэгэхээр та түрүүн сая бид нарт өгсөн ярилцлагандаа одоогийн Арбулаг сумын нутаг Үзүүр ус хэмээх газар байх аа.Тийм газраас бас нүүдэллэн ирсэн байж болзошгүй гэж бас нэг тийм домог шиг яриа байдаг аа гэж ярьж байна тийм ээ. Тэгэхээр Үзүүр хадны хүрээний туурийг, тэр хүрээний талаар мэдээлэл маш хомс байдаг юм байна. Ингээд нутгийн хүмүүстэй ярилцаад, тус сумын харъяат эдүгээ далан таван насыг зооглож

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байгаа өндөр настан, нутгийн олны дунд Ламжав багш хэмээн алдаршсан одоо нэлээн сайн мэргэшсэн зурхайч хүн байна лээ л дээ. Одоо энэ зурхайч Цэнд-Очирын аав гэж ярьж байсан.

Буд: Өө тийм үү?

Мөнхбат: Тийм. Одоо сүүлийн үед гарч ирж байгаа зурхайч байгаа ш дээ, зурхай календарь бичээд байгаа, Цэрэн-Очир гээд. Энэ хүний аав нь гэж байна лээ, төрсөн эцэг нь гэж байсан. Ламжав багш гэж одоо дунд сургуульд олон жил багшилсан ийм өвгөн байна лээ. Энэ өвгөн бол бид нарт ярихдаа, энэ бол Жалханз хутагтын хүрээ энд суурьшиж байсан гэж ингэж ярьж байдаг юм. Тэгэхээр бас таны ярьж байгаатай бол харьцуулаад үзэхэд бол бас ингээд тийм ч оргүй зүйл биш болов уу гэсэн санаа төрж байна.

Буд: Хэддүгээр дүрийнх нь хүрээ юм билээ, Сангийн далайн Ганданд бас байсан. Тэндээс бас ингээд том амьтан гарч ирээд тэндээс бас зайлсан юм. Их тогтворгүй л байж байгаад л тэгээд л хамгийн сүүлийн энэ Жалханз хутагтын наймдугаар дүр энд л ирж одоо их тохижиж, их гоё хүрээ болж, тийм түрүүчийн тэр Эрдэнэбатын ярьснаар бол хориод дугантай, тийм их сайхан тохитой тийм. Цам гардаг, их том Ар халхын шашин номын төв байсан гэдэг нь ямар ч байсан.

Мөнхбат: Үнэн.

Буд: Үнэн.

Мөнхбат: Түүхэн үнэн?

Буд: Тийм, түүхэн үнэн.

Мөнхбат: За ийм, байж. За тэгэхээр хүрээ ид мандан бадарч байхдаа за таныг одоо та 1927 онд долоон настай хүрээнд анх шавилан сууж эхэлсэн. Тийм, долоон настайдаа. Энэ үед таны үзэж харж байснаар хүрээ маань одоо хэд орчим ламтай, за ямар ямар хурал одоо голлон хурдаг, ямар ямар шашны зан үйлийн арга хэмжээ явуулдаг, тэр хүрээ хийдийн сүм дуганы уран барилгын үүднээсээ дорно дахины гүн ухааны хийц загварыг агуулсан зэрэг үүднээсээ харахад одоо ямархуу маягийн хүрээ хийд байж вэ?

Буд: За тэр Жалханзын хүрээ чинь одоо цагаан хүрээ гэж нэг тийм банзаар барьчихсан хашаа байсан юм даа. Тэгээд үүдэн дээрээ одоо асартай хаалгатай. Дотроо болвол гурван ногоон сүм байсан. Гурван ногоон сүм нь одоо за чагдарын сүм байсан санагддаг юм. Улаан сахиус Жамсрангийн дуган гэж байсан санагддаг юм. Тэгээд тэр дотроо бурхан шашны Жалханз гэгээний номын сан гэж байсан. Тэгээд сая тэр нэрүүд нь одоо түрүүн хэлчихсэн.

Мөнхбат: Хорин хоёр дугантай?

Буд: Тийм, хорин хоёр дугантай. За энд бол одоо цогчин, бага хүүхдүүд нь цогчин хурдаг, чойр хурдаг. За тэгээд мамба хурдаг, дүйнхор хурдаг. Жүд...юу, тийм жүд хурдаг. За тэгээд заримыг нь бас одоо хэлж чадахгүй байна аа. Юу билээ, сая өнөө би бас нэг хэлсэн...

Мөнхбат: Гавж, нөгөө дамжаануудынх нь асуудлууд?

Буд: За гавжийн дамжаа барьдаг. Домын дамжаа барьдаг. Ер нь тэгээд...

Мөнхбат: Лам нарын тоо толгой чухам хэр олон байсан юм бол, хэдэн ламтай байсан юм бол, тэр үедээ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Буд: За лам нар чинь одоо бараг мянгаад лам нартай л гэж хойно дуулж байсан байх юм.Тэр үед одоо их л олон лам нар байдаг байсан юм.Тэгээд мянга шахуу лам нартай л гэж амьтан тэгж ярьдаг байсан юм даа, одоо бүр л хүүхэд мүүхэдтэйгээ нийлээд. Раднаа унзад гэж их том дуутай лам байсан. Раднаа унзад бол бүх тэр цам дэглэнэ. Одоо бүх л тэр, Раднаа унзад гуайн ном уншиж байхад л тэр, цан бариад л ном уншиж байхад чинь тэр хүрээгээр ер нь дүү нь хаа хамаагүй л дуулддаг.Их том дуутай лам байсан юм аа, Раднаа унзад гэж.

Мөнхбат: 1937, 1938 оны тэр цөвүүн цаг хүрээ хийдийг бусниулан сүйтгэж, лам нарыг нь хар болгож, дээд эрдэм чадалтай хутагт хувилгаадыг нь баривчилж авч одсон тэр их гашуун хувь тавилан Жалханзын хутагтын хүрээг тойрч өнгөрөөгүй , дайрч гарсан нь лавтай.Тэгэхэд та ид одоо арван долоо, найман настай хүүхэд...Жалханзын хүрээг одоо татан буулгаж, лам нарыг нь хар болгож, том лам нарыг нь баривчилж байсан тэр цаг үеийг та одоо эргэн дурсаж, үлдсэн сэтгэгдлээ бидэнтэй хуваалцана уу?

Буд: За 1932 оны ногооноор тэр лам харын бослого юм даа, одоо тийм юм гаргаад. Тэгээд тэндээ өнөө Жалханзын хүрээн дээр цуглаж байсан улсуудыг бүгдийг нь барьж авч тэр хошууны хашаанд чинь аваачиж хашаад, тэр дотроос нь байхад нь тэр гавж, аграмба тийм мяндагтай улсуудыг ялгаж нэг байшин лүү хийж сахиж хоноод.Маргааш өглөө нөгөөдүүлийг чинь цөмийг нь тууж аваачаад, тэр Жалханзын хүрээний ард талын нэг улаан мод гэдэг нэг модон халзанд аваачиж, тэгээд захаас нь эхлээд хөөж буудсан юм билээ дээ.Тэгэхэд одоо Чойном аграмба гэж лам, тэр миний багш байсан юм.Гарыг нь ар дээр нь хүлчихээд л, тэгээд л тэрэн дээр очоод хажуудахыг нь буудаахлээр, за одоо миний ээлж боллоо гээд хэвтэж байсан, нуруу нь лаг гээд явчихсан.Тэгээд л түрүү тийшээ хараад л уначихсан юм гэнэ лээ.Тэгээд л хэвтээд байсан би ер нь үхээгүй байна гэж бодсон.Хүн үхсэнээ мэддэггүй юм гэнэ лээ гэж өөрөө бодоод, тэгсэн мөртлөө хөлийн хуруугаа сэмхэн өргөөд үзэхэд хөдлөөд байсан гэж байгаа юм.Тэгээд бүрэнхий ч болсон, тэр улсууд чиг явах болоод тэгсэн нэг хүн хүрч ирээд наадах чинь үхэж үү үгүй юу гэж нэгэндээ тэгж хэлсэн.Тэгэхлээр нь нөгөөдөхийг чинь савхин гутлаар шанаад нь өшиглөөд, толгойг нь өөд нь өргөөд тэгээд хаясан гэж.Тэгээд үхжээ гээд яваад өгсөн юм гэнэ лээ.Тэгээд л өөрөө чимээгүй болохлээр нь шөнө босоод. Хоёр гар нь ардаа хүлээтэй, өдөр шөнө хоёр юу ч амсаагүй.Тэгээд хүрээ рүү ороод нэг шавийндаа очоод дуудсан юм гэнэ лээ. Тэгээд тэр шавь нь гарч ирж хүлээг нь тайлж, тэгээд нэг юм идэж жаахан тэнхэрч тэгээд тэр гангын мод гээд баруун талд нь баахан модтой уул байдаг юм.Мод руу очоод, модонд очоод тэндээ зусаад. Тэгээд намар өвөл болсон хойно нөгөөдөх чинь бууж ирж, тэр хүрээн дээр орж ирж, шавийндаа ирээд тэрүүгээр л хоол үнд зөөлгөж байсан юм байна л даа. Тэгээд хөдөө гараад, лам нар тараад явчихсан, тэр үед чинь гучин хоёр онд тэгээд тэр чигтээ л хүрээ нь бүр эзгүй болчихсон байсан л даа.Тэгээд дээд нөгөө мэддэг улсуудыг нь алаад байхгүй болчихсон юм чинь. Тэгээд хойтон жил нь тэр үед хотод байж байсан юм чинь лам нарууд нь амьд үлдээд, тэднуус нь хүрч ирж тэр цамаа сэргээгээд...

Мөнхбат: Хурал номоо сэргээгээд?

Буд: Хурал номоо сэргээгээд, тэгээд 1933, 1932 ондоо тэгж өнжчихөөд, гучин гурван ондоо...

Мөнхбат: Дахин сэргээгдээд?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Буд: Дахин сэргээгдээд, тэгэхдээ бүх цамаа гараад, тэгээд одоо нөгөө цамын баг маг хийх юм олддохгүй.Өнөө айлуудын авгайчуулын, гоё авгай нарын хувцсыг худалдаж авч ингээд цамын хувцсаа гүйцээлээ л гэж ярьж байсан юм.Тэгэхлээр тэр шамба гэж, гучин хоёр улаан сахиус гэж байдаг байсан юм.Нөгөө улаан сахиустай гучин хоёр, тэгээд тэр нь гүйцээгээд би тэр нөгөө хорин нэгэн улаан титэг цам гэж байсан юм. Тэр хорин нэгэн титэг цамд одоо арван хэдэн орчимд миний нуруу таардаг.Хамгийн багад нь одоо манай энд одоо хэн гэж байсан. Раднаа гэж хүн байсан. Өнөө хэн билээ, Раднаа байх аа.Раднаа хамгийн жижиг нь.Тэр маань тугал цам гэж тийм хамгийн бага нуруутай.Тугал шиг тийм эвэртэй баг өмсөөд, тэгээд тэр цамаа гүйцээгээд тэгж байтал тэр сарвагар Жаамаа гэдэг хүн намын дарга байсан юм.Тэр сарвагар Жаамаа намын дарга байж байгаад нэг цам гарахад орж ирсэн.Бүлгэмд орж ирсэн учраас энэ долоо найман улсуудыг, хар улсуудыг цамд оруулахгүй гээд хориод тийм, уг нь ерэн найман цам гарах ёстой байсан юм л даа. Тэгээд тэрнээс чинь тав, зургаан улсуудыг хар улсууд гээд гаргачихаар цам нь арай дэг нь гүйцээгүй.Арай дутуу цам гараад.Ингээд тэр гучин хоёр ондоо цамаа гараад, майдраа эргээд, тэгээд л гучин хоёр ондоо нөгөө хэдэн лам нар цамаа майдраа эргэж аваад л тэгээд л дууссан.Тэгээд л тэрнээс хойш үндсэндээ, гучин гурван ондоо, гучин гурван ондоо цам майдраа сэргээж гаргаж ирсэн.Тэгээд л устаад л тэр хүрээ тэр чигтээ нурсаар нурсаар л байгаад л, тэгээд л ийшээ тийшээ амьтан барьж авсаар байгаад л юмнууд нь дуусаад.Тэгсээр байтал намар найман сард Мөрөнд нэг эгчийгээ эмчлүүлээд очиход тэнд цогчин дуганд аваачаад, хүрээ хүрээний тэр баг юмнуудыг нь аваачаад өвс бүхалдчихсан юм шиг овоолчихсон байсан, дуган дотор.Тэгээд л нэг өдөр энд орой гал гараад, цогчин дуган шатаад, тэгээд тэнд байсан бүх юмнууд тэгээд шатсан.Тэрнийг бол ерөөсөө хүн шатаасан л гэж улсууд ярьдаг юм байна лээ.Юм асгаад л , гал гаргасан гэж дуган дотор.Тэгээд тэрний хажуу талд байсан хоёр дуган шатаад.Тэгэхэд чинь гал команд гэж байдаггүй. Хатгалд байдаг байсан.Хатгалаас гал команд ирэхэд хоёр дуган шатаад дууссан.Баруун тал руугаа хоёр гудам шатаад, гудмын айлууд.Тэгээд тэгж байх дээр гал команд хүрч ирж хавийн дугануудыг услаад, усан хөөргөөр цацаж услаж тэгж бусдыг нь хамгаалж аварч ирсэн юм даг.

Мөнхбат: Тэр одоо гал командтай болчихсон Хатгал хот Хөвсгөл аймгийн төв болчихсон байсан үе үү, тэр үе?

Буд: Тийм, Хөвсгөл аймаг чинь аймгийн төв Хатгалд байсан үе.

Мөнхбат:Тэр хэдэн он бэ, дөчөөд оны үе болж байна уу?

Буд:Үгүй ээ, тэрнээс чинь урдаар...

Мөнбат: Гучин хэдэн он үү?

Буд: Тийм, гучин найм , хорин найм...За хорин найм, гучин найман онд чинь. Аймгийн төв Хатгалд байсан юм шүү дээ.Тэр хамгийн түрүүнд одоо улаан Гомбосүрэн, Жүгдэр гээд нэг гурван хүн баригдаад явж байлаа гэж дуулдаж байсан юм. Тэгээд тэр нэг одоо Жүгдэрийн ээж Думаа гээд нэг чавганц байсан.Тэр ээ дээ одоо миний хүүгийн махыг одоо шарж идэж байгаа даа, энэ улааныхан гээд хөөрхий тэгж хэлдэг байсан юм даг, тэр баригдаж аваад явж байхад нь.Тэр улаан Гомбосүрэн, тэр Жүгдэр наад нэг хүнийг нь мартчихаж.Тэр гурван хүнийг аймгийн төв рүү Хатгалд аваачаад шууд тэр Хатгалын улаан модон дотор алж гэнэ ээ гэж тэр хойно нь дуулдаж байсан юм.Тэгээд л тэрнээс хойш тэр гавж, аграмба гэдэг улсуудыг чинь л ер нь тэр мяндагтай

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

улсуудыг цөмийг нь л дүүргээд.Тэр жаахан тэр үед чинь л овоохон одоо малтай, өөрийн ариун цагаан хөдөлмөрөөрөө баяжаад овоо малтай хөрөнгөтэй болчихсоныг хар феодал гээд, эгээтэй ардуудыг нь тэгээд баривчлаад явчихдаг. Наад лам нарыг нь болохоор шар феодал гээд, ингээд..

Мөнхбат: За ингээд Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч ван хошууны буддын шашны томоохон төв болсон Жалханз хутагтын хүрээ хийдийн тухай бид нарт одоо мэдээлэл өгсөн Буд гуай танд баярлалаа.Таны өгсөн энэ мэдээлэл монголын сүм хийдийн түүхэн товчоо төслийн судалгааны багийн ажилд болон цаашилбал монголын түүх соёлын дурсгалыг өвлөх хамгаалах сурталчилах энэ үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.Ингээд танд урт удаан наслахыг хүсэн ерөөе өө.

Буд: За цааш цаашдаа ажлаа сайхан амжуулаад, энийг одоо жинхэнэ зөвөөр нь үнэн тодруулж түүх болгож энийг гаргаж ирж байгаа та бүгддээ их баяртай байна.Одоо ингээд энийг ингэж сэргээж явдаг чинь болвол одоо их баяртай байна даа. Сайн байна.

Мөнхбат:За баярлалаа.